




Усны хомстлоос сэргийлэх МАН-ын стратеги



Сонгуулийн сурталчилгаанд зориулсан уг нийтлэлд Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийг МАН-ын мөрийн хөтөлбөрийн нэг хэсэг болгон оруулжээ. Улаанбаатар хотын ус хангамжийн Баруун шинэ эх үүсвэрийг байгуулж, ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг Сонгинохайрхан уулын бэлд барьж, ашиглалтад оруулах ажлыг Нийслэлийн Монгол Ардын Намын хороо Нийслэлийн ИТХ-ын 2020 оны сонгуульд дэвшүүлэн оролцож буй мөрийн хөтөлбөртөө онцолжээ. [Эх сурвалж: https://ikon.mn/n/20b1](https://ikon.mn/n/20b1)

Д.Басандорж: Бид хэрэглээний усныхаа 60 хувийг жорлонд урсгадаг



“Өнөөдөр манай улс ахуйн хэрэглээндээ цэвэр усаа татаад, бохиоро цааш нь явуулдаг тогтолцоотой байгаа. Энэ нь бид хэрэглэж буй усныхаа 60 хувийг жорлонгоороо асгачихаж байна гэсэн үг. 200 литр ус хэрэглэж байна гэж бодоход 140 литрийг бид зөвхөн бие засахдаа хэрэглээд, жорлонгоороо дамжуулан урсгаж байна. Нэг татахдаа 13 литр ус урсгаж байна. Ус нь үнэ цэнэгүй үнэлэмжгүй, усаа хэмнэх эрх зүй, эдийн засгийн бодлого шийдэл байхгүйгээс “Усаа хайрлая” гэж хоосон шоудаж ярьцгаагаад, амьдрал практик дээр хэрэгжүүлж байгаа зүйл алга” гэв. [Эх сурвалж: https://montsame.mn/mn/read/239214](https://montsame.mn/mn/read/239214)

Газрын доорх усны хяналт-удирдлагын порталын хөгжүүлэлтийн ажлын явцыг танилцуулав



Дэлхийн банкны дэргэдэх “2030 Усны нөөцийн бүлэг” Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар хийж гүйцэтгэж буй газрын доорх усны хяналт-удирдлагын порталын хөгжүүлэлтийн ажлын явцыг Усны газрын хамт олонд танилцуулав. Уулзалтын гол зорилго нь газрын доорх усны хяналт- шинжилгээний сүлжээний портал хөгжүүлэлтийн дараагийн алхамуудыг тодорхойлох, хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд хамтран ажиллах талаар санал солилцлоо. [Эх сурвалж: Усны газрын албан ёсны Фэйсбүүк хуудас](#)

Ирэх 1000 хоногт БОАЖЯ-ны усны салбарт хийж гүйцэтгэх гол ажлууд



Шинэ Засгийн газар бүрэлдээд 100 хоног өнгөрч байгаатай холбогдуулан БОАЖЯ-наас энэ хугацаанд хийж, хэрэгжүүлсэн тоонцлон танилцуулсан дүрс бичлэгийг олон нийтэд хүргэв. Уг бичлэгийн 1000 хоногт БОАЖЯ-ны хийж гүйцэтгэх гол ажлуудад Хөвсгөл нуурт экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгаа хийж, нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулах, Усны нөөцийг бохирдол, хомстлоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, Нийслэлийн цэвэр усны хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, цэвэрлэсэн болон дахин боловсруулсан хаягдал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах, цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55 хувийг улсын тусгай хамгаалалтад авах, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээх зэрэг ажлыг багтаажээ. [Эх сурвалж: БОАЖЯ-ны албан ёсны фэйсбүүк хуудас](#)

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиар сургалт зохион байгууллаа

ТЕГ-ын Татвар төлөгчид үйлчлэх газар, Татвар хураалт удирдлага арга зүйн газраас Том татвар төлөгчийн газар, Нийслэл дүүргийн татварын хэлтсийн сегментийн ахлах байцаагч, тухайн татварын төрөл хариуцсан байцаагч нарыг оролцуулан Ус бохирдуулсны тухай хуулиар сургалт зохион байгуулжээ. Сургалтын үеэр Усны газар болон ТЕГ-ын холбогдох мэргэжилтнүүд Ус бохирдуулсны төлбөр төлөгчийг бүртгэх, тайлан хүлээн авах, Ус бохирдуулсны төлбөр, төлөвлөгөөний гүйцэтгэл зэрэг сэдвээр танилцуулга хийсэн байна. [Эх сурвалж: Усны газрын албан ёсны Фэйсбүүк хуудас](#)

Товч мэдээлэл

- ⇒ Уул уурхай, хүнд үйлдвэрийн Дэд сайд О.Батнайрамдал Өмнөговийн уул уурхай, хүнд үйлдвэрийн бүсийн усны эрэлт-хангамжийн гидроэкономик шинжилгээний үр дүнг Дэлхийн банкны “2030 Усны нөөцийн бүлэг”-ээс хүлээн авлаа. [\(Монгол Улсын Усны салбар фэйсбүүк хуудас\)](#)
- ⇒ “Ноос Ирээдүй” ХХК үйлдвэрээс гарсан хаягдал усаа дахин ашигладаг боллоо. <http://www.etv.mn/?p=15262>
- ⇒ Хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, хөгжлийн стратеги, экспортын чиг хандлагын талаарх эрдэм шинжилгээ, онол практикийн хурал боллоо. Жилдээ хэрэглээд 10 сая малын арьс шир ноос ноолуурыг хэрхэн эцсийн бүтээгдэхүүн болгон олон улсад гаргах болон салбарт тулгарч буй өнөөгийн бодит байдлыг хэлэлцэв. МХАУТ-ийн дарга Т.Дүүрэн энэ салбарт экспортыг дэмжсэн тусгай нөхцөлтэй зээл гаргах ёстой гэжээ. [Эх сурвалж: БОАЖЯ-ны албан ёсны фэйсбүүк хуудас.](#)